



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2010 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 281

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн "Журам батлах тухай" 177 тоот тогтоолоор баталсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам", Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар баталсан "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам"-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Гадаадад зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 458 дугаар тушаалын Бүрэнтогтох овогтой Наранжаргалын холбогдолтой хэсгийн "АНУ-ын Калифорнийн их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жил" гэснийг "АНУ-ын Northwestern Политехникийн их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жил", "Гадаадад зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 476 дугаар тушаалын Даваадорж овогтой Тэлмэнтэй холбогдолтой "Харвардын их сургуулийн" гэснийг Австралийн Үндэсний их сургуулийн" гэж тус тус өөрчилсүгэй.

2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан/Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД



Ё.ОТГОНБАЯР